БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/73

танай____________-ны № ______________ -т

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.УУГАНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн сумын Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Бараа үйлчилгээний зардлаас гэрээ, тушаал шийдвэргүйгээр багш нарт явуулах сургалтын зардал 550.0 мянган төгрөгийг олгосон байна.

Мөн 352,704.3 мянган төгрөгөөр барилга байгууламж, 352,704.3 мянган 14,807.0 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 1,970.9 мянган төгрөгөөр тавилга эд хогшил тус тус хөрөнгө нэмэгджээ.

5020278

**Аудитын гол асуудал**

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 35,150.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийг өсгөж төсөвлөсөнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 12 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 46 арга хэмжээг бүрэн 100 хувь, 2 арга хэмжээг 72 хувь, дараа он дамжих 1 хөтөлбөр 58 хувь, нийт дүнгээр 98.0 хувиар биелүүлж, биелэлтийг дээд байгууллагат хүргүүлснээр, дээд байгууллагаас 98.0 хувиар дүгнэгдсэн.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/52/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn 2024 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......................................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
   4.1 Ерөнхий зүйл ......................................................................................................................................
   4.2 Материаллаг байдал .........................................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..........................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...........................................................................................
5. Аудитын илрүүлэлт ...........................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **85,008,406.20** | **99,788,184.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 34,195,582.00 | 75,897,092.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 34,195,582.00 | 75,897,092.00 |
| **3121** | **Төгрөг** | 34,195,582.00 | 75,897,092.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 34,195,582.00 | 75,897,092.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 50,372,917.20 | 23,891,092.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,240,000.00 | 3,240,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 35130 | Эм боох материал | 240,000.00 | 240,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,132,917.20 | 20,651,092.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,188,036.00 | 3,743,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 39,944,881.20 | 16,908,092.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **792,420,908.34** | **1,090,548,512.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 792,420,908.34 | 1,090,548,512.89 |
| **392** | **Биет хөрөнгө** | 772,896,908.34 | 1,071,024,512.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 858,547,377.00 | 1,211,251,679.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -246,723,532.28 | -278,018,487.59 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 277,808,489.91 | 232,801,596.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -169,649,794.82 | -128,814,810.87 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,787,235.10 | 82,789,207.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -71,533,872.88 | -65,354,512.12 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 46,741,537.12 | 46,741,537.12 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -33,572,998.41 | -37,572,998.37 |
| 39217 | Ном | 15,492,467.60 | 7,201,301.82 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,524,000.00 | 19,524,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,524,000.00 | 19,524,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **877,429,314.54** | **1,190,336,696.89** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **210,010.00** | **48,473.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 210,010.00 | 48,473.00 |
| **413** | **Өглөг** | 210,010.00 | 48,473.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 48,473.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **877,219,304.54** | **1,190,288,223.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 877,219,304.54 | 1,190,288,223.89 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 290,170,245.35 | 290,170,245.35 |
| 51101 | Өмч: - төрийн | 290,170,245.35 | 290,170,245.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 27,949,961.97 | 345,146,650.32 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 27,949,961.97 | 32,077,730.97 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 313,068,919.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 559,099,097.22 | 554,971,328.22 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **877,429,314.54** | **1,190,336,696.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон**

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **765,900,999.00** | **1,225,062,106.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,697,310.00** | **361,989,206.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,697,310.00 | 361,989,206.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 56,700.00 | 1,304,904.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,700.00 | 1,304,904.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **734,203,689.00** | **863,072,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 599,880,900.00 | 733,476,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 134,309,200.00 | 129,596,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,309,200.00 | 129,596,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **752,064,372.18** | **903,702,020.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **752,064,372.18** | **903,702,020.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 695,285,172.18 | 850,657,565.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 439,030,756.00 | 511,922,247.10 |
| 210101 | Үндсэн цалин | 314,294,443.00 | 355,283,981.10 |
| 210102 | Нэмэгдэл | 94,534,539.00 | 129,546,920.00 |
| 210104 | Урамшуулал | 5,492,889.00 | 27,091,346.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,598,500.00 | 66,560,782.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,156,491.03 | 45,758,561.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,269,184.47 | 5,173,974.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,401,910.18 | 4,219,099.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 848,136.77 | 1,037,311.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,922,777.55 | 10,371,836.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,939,287.00 | 102,934,944.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,576,727.00 | 7,905,580.21 |
| 210302 | Түлш, халаалт | 77,362,560.00 | 95,029,364.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,166,590.00 | 8,655,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,602,000.00 | 8,655,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,254,424.00 | 38,748,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,254,424.00 | 38,748,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,551,000.00 | 5,999,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,551,000.00 | 5,999,400.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,355,760.00 | 31,941,759.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,700.00 | 26,483,389.20 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,299,060.00 | 5,458,370.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 79,388,855.18 | 83,895,131.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,922,285.00 | 12,851,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 61,711,730.18 | 71,043,431.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,779,200.00 | 53,044,455.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,613,839.00 | 32,382,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,071,350.00 | 23,629,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,542,489.00 | 8,752,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,165,361.00 | 20,662,455.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,165,361.00 | 20,662,455.79 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,836,626.82** | **321,360,085.13** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 8,291,165.78 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 8,291,165.78 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -8,291,165.78 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **13,836,626.82** | **313,068,919.35** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31нээрх үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **27,949,961.97** | 877,219,304.54 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31нээрх үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **27,949,961.97** | 877,219,304.54 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 4,127,769.00 | 4,127,769.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **32,077,730.97** | 881,347,073.54 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -4,127,769.00 | 00.00 | -4,127,769.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 313,068,919.35 | 313,068,919.35 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31нээрх үлдэгдэл** | **290,170,245.35** | **554,971,328.22** | **345,146,650.32** | 1,190,288,223.89 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **734,260,389.00** | **864,377,804.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,700.00** | **1,304,904.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 56,700.00 | 1,304,904.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 56,700.00 | 1,304,904.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,700.00 | 1,234,904.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **734,203,689.00** | **863,072,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 599,880,900.00 | 733,476,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 599,880,900.00 | 733,476,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 134,309,200.00 | 129,596,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,309,200.00 | 129,596,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **688,377,807.00** | **805,898,394.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **688,377,807.00** | **805,898,394.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **635,234,967.00** | **752,853,938.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 439,030,756.00 | 511,913,005.10 |
| 210101 | Үндсэн цалин | 314,294,443.00 | 355,274,739.10 |
| 210102 | Нэмэгдэл | 94,534,539.00 | 129,546,920.00 |
| 210104 | Урамшуулал | 5,492,889.00 | 27,091,346.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,598,500.00 | 66,081,644.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,156,491.03 | 45,279,423.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,269,184.47 | 5,173,973.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,401,910.18 | 4,219,099.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 848,136.77 | 1,037,312.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,922,777.55 | 10,371,836.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,939,287.00 | 102,934,944.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,576,727.00 | 7,905,580.21 |
| 210302 | Түлш, халаалт | 77,362,560.00 | 95,029,364.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,680,774.00 | 38,748,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,680,774.00 | 38,748,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,551,000.00 | 5,999,400.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,551,000.00 | 5,999,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,883,760.00 | 3,056,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,700.00 | 626,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,827,060.00 | 2,430,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,550,890.00 | 24,120,344.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,174,050.00 | 19,071,044.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,376,840.00 | 5,049,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,142,840.00** | **53,044,455.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,977,479.00 | 32,382,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,645,000.00 | 23,629,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,332,479.00 | 8,752,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,165,361.00 | 20,662,455.79 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,165,361.00 | 20,662,455.79 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **45,882,582.00** | **58,479,410.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,687,000.00** | **16,777,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,687,000.00** | **16,777,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,687,000.00 | 16,777,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,687,000.00 | 16,777,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-11,687,000.00** | **-16,777,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 34,195,582.00 | 41,701,510.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 34,195,582.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 34,195,582.00 | 75,897,092.00 |

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 898,223,100.00 | 802,013,838.21 | 96,209,261.79 | 89.3 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 898,223,100.00 | 802,013,838.21 | 96,209,261.79 | 89.3 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 855,422,500.00 | 769,631,838.21 | 85,790,661.79 | 90.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 569,956,900.00 | 511,913,005.10 | 58,043,894.90 | 89.8 |
| 210101 | Үндсэн цалин | 397,422,100.00 | 355,274,739.10 | 42,147,360.90 | 89.4 |
| 210102 | Нэмэгдэл | 145,247,600.00 | 129,546,920.00 | 15,700,680.00 | 89.2 |
| 210104 | Урамшуулал | 27,287,200.00 | 27,091,346.00 | 195,854.00 | 99.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,245,000.00 | 66,081,644.90 | 5,163,355.10 | 92.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,446,600.00 | 45,279,423.32 | 3,167,176.68 | 93.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,699,600.00 | 5,173,973.79 | 525,626.21 | 90.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,559,600.00 | 4,219,099.15 | 340,500.85 | 92.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,140,000.00 | 1,037,312.04 | 102,687.96 | 91.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,399,200.00 | 10,371,836.60 | 1,027,363.40 | 91.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 123,596,800.00 | 102,934,944.21 | 20,661,855.79 | 83.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000.00 | 7,905,580.21 | -905,580.21 | 112.9 |
| 210302 | Түлш, халаалт | 114,796,800.00 | 95,029,364.00 | 19,767,436.00 | 82.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,749,000.00 | 38,748,000.00 | 1,000.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 38,749,000.00 | 38,748,000.00 | 1,000.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,000,000.00 | 5,999,400.00 | 600.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 5,999,400.00 | 600.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,992,900.00 | 3,056,600.00 | 936,300.00 | 76.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 626,600.00 | 626,600.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,366,300.00 | 2,430,000.00 | 936,300.00 | 72.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41881900.00 | 40898244.00 | 983,656.00 | 97.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,832,400.00 | 35,848,944.00 | 983,456.00 | 97.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,049,500.00 | 5,049,300.00 | 200.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 42800600.00 | 32382000.00 | 10,418,600.00 | 75.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,800,600.00 | 32,382,000.00 | 10,418,600.00 | 75.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,048,100.00 | 23,629,500.00 | 10,418,600.00 | 69.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,752,500.00 | 8,752,500.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 898,223,100.00 | 864,377,804.00 | 33,845,296.00 | 96.2 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 768,626,300.00 | 733,476,100.00 | 35,150,200.00 | 95.4 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 768,626,300.00 | 733,476,100.00 | 35,150,200.00 | 95.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 129,596,800.00 | 129,596,800.00 | 0.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 129,596,800.00 | 129,596,800.00 | 0.00 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 1,304,904.00 | -1,304,904.00 | -100.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,304,904.00 | -1,304,904.00 | -100.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 34,195,582.00 | - 34,195,582.00 | -100.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 75,897,092.00 | - 75,897,092.00 | -100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 38.00 | 37.00 | 1.00 | 97.4 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **38.00** | **37.00** | 1.00 | 97.4 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль,



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 312,907.30 мянган төгрөгөөр буюу 35.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 34,195.6 | 75,897.1 | 41,701.5 |
| Авлага | 439.9 | 0.0 | -439.9 |
| Бараа материал | 50,372.9 | 23,891.0 | -26,481.9 |
| Үндсэн хөрөнгө | 792,420.9 | 1,090,548.5 | 298,127.6 |
| **Нийт хөрөнгө** | **877,429.3** | **1,190,336.7** | **312,907.3** |
| **Өглөг** | **210.0** | **48.5** | **-161.5** |
| Засгийн газрын хувь оролцоо | 290,170.2 | 290,170.2 | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 27,950.0 | 345,146.7 | 317,196.7 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 559,099.1 | 554,971.3 | -4,127.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **877,429.3** | **1,190,336.7** | **312,907.3** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 75,897.10 мянган төгрөг болж 47,701.5 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.

Авлага данс үлдэгдэлгүй болж 439.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажиллагсадтай өгөх 439.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 23,891.0 мянган төгрөг болж, 26,481.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 17,876,7,8 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг өмнөх оны үлдэглээс акталсан, 7,980.0 мянган төгрөгийн бараа материалыг бүтэцийн өөрчлөлтөөр шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,190,336.70 мянган төгрөг болж, 312,907.30 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд барилга байгууламж, орон сууц дансанд 352,704.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын засвар, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансуудад 16,777.9 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хииийсэн, мөн аймгийн иргэдийн хурлын 2023 оны 10 дугаар сарын



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

14-ний өдрийн хуралдааны 08/15 тоот тогтоолоор нэр 2 данснаас 91,053.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасалт хийсэн, тайлант онд 71,043.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 459,161.2 мянган төгрөг буюу 61.8 хувиар өсч, нийт зардал өмнөх оноос 151,637.6 мянган төгрөг ба 20.1 хувиар нэмэгдэж тайлант оны үр дүн 313,068.9 мянган төгрөгөөр ашигтай ажилласан нь хуримтлагдсан үр дүн 317,196.70 мянган төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,098,476.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 145,800.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 329,850.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 16,203.2 мянган төгрөгөөр бууруулж баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс буурсан байгаа нь төсвийг бодит бус, буруу төсөвлөж байгаатай холбоотой байна.

Дээрх баталсан төсвөөс санхүүжилтийг бүрэн олгож, төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 20,662.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, нийт 75,897.1 мянган төгрөг хэмнэсэн нь улсын төсвөөс санхүүжсэн цалин, урсгал шилжүүлэг, хоол хүнсний зардлуудыг, орон нутгийн төсвөөс санхүүжих гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, эд хогшил урсгал засварын зардалуудыг тус тус хэмнэж, хэмнэсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн хүрээнд 49 арга хэмжээнд 733,476.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 129,596.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, үндсэн болон туслах үйл ажллагааны орлогоос 1,304.9 мянган, нийт 864,377.8 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 733,476.1 мянган, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоос 1,304.9 мянган, 129,596.8 мянган төгрөгийг орон нутгийн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төсвөөс, 1,304.9 мянган төгрөгийн үйл ажиллагаанаас бүрдүүлж, нийт 864,377.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Орон нутгийн төсвөөс байр ашиглалтын зардалд 102,934.9 мянган, улсын төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 577,994.6 мянган, нормативт зардалд 38,748.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 40,898.2 мянган, бусад урсгал шилжүүлгийн зардалд 32,382.0 мянган, нийт 802,013.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 20,662.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 802,013.8 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71601 | Ерөнхий Боловсролын сургалт | 898,223.1 | 802,013.8 | 96,209.3 | 89.3 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 784,178.1 | 703,550.2 | 80,627.9 | 89.7 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 71,245.0 | 66,081.6 | 5,163.4 | 92.8 |
| 83112 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 42,800.0 | 32,382.0 | 10,418.0 | 75.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 66,261.8 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны харьцуулалтын болон гэрээгээр тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 101,598.2 мянган төгрөгийг худалдан авсан байна. Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 16,777.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар, харьцуулалтын тендерийн аргаар үдийн цай хөтөлбөрийн 62,377.5 мянган төгрөгийг, харин бусад хангамж бичиг хэргийн 22,444.8 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 төсөв 749,712.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,497.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,247.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 63,207.2 мянган, байр ашиглалтын зардлыг 20,661.9 мянган, нормативт зардалд 0.6 мянган, бусад



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

урсгал шилжүүлэгийн зардалд 10,418.6 мянган төгрөгийн зарлуудыг, нийт улсын төсвийг зардлыг 75,897.1 мянган төгрөгөөр төөөрвлөрүүлэн, хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, таван саяас дээш 153,169.8 мянган төгрөгийн зарлагын 16 гүйлгээг, 722,659.1 мянган төгрөгийн орлогын 37 гүйлгээг бүрэн мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 100 хувь байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,518,901.4 мянган төгрөгийн 120 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцсэн бөгөөд аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаж байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон 694.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,774.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 694.1 | 1 | 694.1 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 1,774.3 | 1 | 1,774.3 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 3 | 2,468.4 | 3 | 2,468.4 | 100.0 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 9,790.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Бага, дунд өврын 10 ширхэг компютерыг 9,790.0 мянган төгрөгөнд худалдан авч, гэрээ дүгнэсэн акт, тооцоо нийлсэн актыг үйлдэж баримтжуулаагүй байсныг аудитын явцад хийж залруулсан болно.

Аудитаар 550.0 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил байхгүй нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,247.9 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчилгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

**5.1.1.1 Төлбөрийн акт**

Үндэслэх шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр сургалтын зардал болох 550.0 мянган төгрөгийг хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар толооын 1.3 -т "байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;"гэж заасныг тус тус зөрчсөн нь аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бараа үйлчилгээний зардлаас гэрээ, тушаал шийдвэргүйгээр багш нарт явуулах сургалтын зардал 550.0 /Таван зуун тавин мянган/ төгрөгийг хувь хүнд олгосныг Төсвийн шууд захирагчаар албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бага, дунд оврын 10 ширхэг компьютерыг 9,790.0 мянган төгрөгөөр худалдан авч, гэрээ дүгнэсэн акт, тооцоо нийлсэн актыг үйлдэж баримтжуулаагүй байсныг аудитын явцад хийж залруулсан болно. | 1 | 9,790.0 | | | 1 | 9,790.0 | 1 | 9,790.0 | | | 1 | 9,790.0 |
| Дүн | 1 | 9,790.0 | 0 | 0 | 1 | 9,790.0 | 1 | 9,790.0 | 0 | 0 | 1 | 9,790.0 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа үйлчилгээний зардлаас үндэслэх шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр сургалтын зардал болох 550.0 мянган төгрөгийг хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн байна. | 1 | 550.0 | 1 | 550.0 | | | | |
| Дүн | 1 | 550.0 | 1 | 550.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил*** | | | | | | |
| | | | | | | |
| Дүн | | | | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ